

# “ТЭЛМЭНИЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Шинэ азиа групп ХХК-ийн 2020 оны 01/41 дугаар хүсэлтийг тус тус үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /“Эрх бүхий этгээд”/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Шинэ азиа групп” ХХК, түүнийг төлөөлж Ерөнхий захирал Л.Төрбаяр /концесс эзэмшигч”/ нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулав.

## НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Тэлмэний дулааны цахилгаан станц төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 3.4.1.7 дахь заалтын “Цахилгаан станцын эхний ээлжийн нэг турбин нэг зуухыг /50МВт/ 2014 оны 12 дугаар сарын дотор барьж, ашиглалтад оруулна;” гэснийг “Цахилгаан станцын барилга угсралтын ажлыг 2020 онд багтаан эхлүүлж, эхний ээлжийн турбин зуухыг /50МВт/ барилга угсралтын ажил эхэлснээс хойш 24 сарын хугацаанд ашиглалтад оруулна.” гэж өөрчлөн найруулав.

## ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү Нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд “Тэлмэний дулааны цахилгаан станц төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд концессын гэрээний хугацаанд адил хүчинтэй байна.

2.2. Энэхүү Нэмэлт гэрээг адил хүчинтэй 3 хувь үйлдэв.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ ӨТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг: .....

Нэр: Б.Баярсайхан

Албан тушаал: Үндэсний хөгжлийн газрын дарга

Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг: .....

Нэр: Л.Төрбаяр

Албан тушаал: Шинэ азиа групп ХХК-ийн Ерөнхий захирал

Тамга:

